



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

176 /176/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.11



ТУСГАЙ ДУГААР



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБА-50 ЖИЛ

МЭНДЧИЛГЭЭ



хариуцлагатай албанд хоёргүй сэтгэлээр зүтгэж байгаа хамт олондоо баярын мэндийг дахин дэвшүүлж, эрүүл энх, аз жаргал, ажлын амжилтыг хүсэн ерөөе.

Монгол цэргийн сүр хүч, эрдэм чадал мөнхөд мандан бадарч, алтан шар зам өлзийтэй байх болтугай!

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫ ДАРГА,
ХУРАНДАА Л.БАЯРЦОГТ

Зэвсэгт хүчин хэмээх өнөр бүлд өрх нэмж Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба үүссэн байгуулагдаад 50 дахь жилтэйгээ золголоо. Тус алба байгуулагдсан цагаасаа батлан хамгаалах салбарын хэмжээнд автотехникийн бэлэн байдал, ашиглалт, тавиулангийн албыг хэвшүүлэхэд төрийн хяналт, шалгалт явуулах, нэгтгэл, анги, байгууллагуудын техникийн ажилтан, жолооч нарын замын хөдөлгөөний дүрэм, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон улсын хамтарсан болон анги, байгууллагуудын хээрийн сургууль, дадлага, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабын гадаад харилцаа, хамтын ажиллагааны шугамаар хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчидтэй холбоотой болон төрийн ёслол, бусад нэгдсэн үйл ажиллагаануудын үед замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахын зэрэгцээ Зэвсэгт хүчний хөдөө орон нутаг дахь цэргийн хүрээ, хотхонд тээврийн хяналтын байцаагчдыг томилуулан ажиллаж байна.

Тус албыг өнөөг хүртэл ажил үүргээ тасралтгүй үргэлжлүүлэхэд мэргэжлийн боловсон хүчин, орчин үеийн техник хэрэгслээр байнга дэмжлэг үзүүлж ирсэн Батлан Хамгаалах Яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Тээврийн цагдаагийн албаны үе үеийн удирдлага, бие бүрэлдэхүүнд талархаж буйгаа энэ ташрамд илэрхийлье. Бидний үлгэр дуурайлал болсон ахмад үеэсээ суралцаж, тэдний үйл хэргийг нэр төртэй залгамжлан ажиллаж байгааг тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанд залуу халуун нас, эрч хүч оюун ухаанаа зориулан ажиллаж ирсэн үе үеийн алба хаагчид болон өдгөө энэ



2011/05/01

ҮЕ ҮЕИЙН ДАРГА НАР

ҮЕ ҮЕИЙН АХЛАХ БАЙЦААГЧ НАР

- Хошууч Ц.Жодов 1971-1977 онд
- Дэд хурандаа Г.Доржсүрэн 1977-1983 онд
- Дэд хурандаа Ц.Шархүү 1984-1990 онд
- Дэд хурандаа Ш.Энхсайхан 1990-2000 онд
- Дэд хурандаа Б.Цог-Эрдэнэ 2000-2007 онд
- Хурандаа Л.Баярцогт 2007-2013 онд
- Дэд хурандаа Б.Болдбаатар 2013 онд
- Дэд хурандаа Ц.Энхтөр 2013-2015 онд
- Хурандаа Л.Баярцогт 2016 оноос

- Дэд хурандаа М.Дарьзав 1972-1976 онд
- Дэд хурандаа Я.Пеодор 1976-1979 онд
- Хошууч Ш.Аюуш 1979-1987 онд
- Дэд хурандаа Д.Эрдэнэбат 1993-2006 онд
- Дэд хурандаа Б.Болдбаатар 2006-2013 онд
- Хошууч Ч.Батболд 2013-2016 онд
- Хошууч Г.Отгонбаатар 2016-2018 онд
- Хошууч Ч.Батболд 2018 оноос
- Хошууч М.Мөнхбаяр 2021 оноос

ТҮҮХЭН ЗАМНАЛ

Батлан хамгаалахын сайдын 1971 оны 333 дугаар тушаалаар Цэргийн автотехникийг шалгах албыг анх удаа зохион байгуулан БХЯ-ны төрөл бүрийн автомашины ашиглалт, авто хөсгийн хөдөлгөөнийг шалган зохицуулах ажлыг хариуцан гүйцэтгэх үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа эхэлжээ. Тухайн үед тус алба нь 28 албан хаагч, гурван нэгж техниктэй үйл ажиллагаа явуулж байв.

Цэргийн автотехникийг шалгах албаны анхны даргаар хошууч Ц.Жодов ажиллаж албаны ажиллах дүрэм журмыг боловсруулж баталгаажуулан цэргийн албыг хэвшүүлэх, автомашины ашиглалт, хөдөлгөөнийг шалган зохицуулж Улаанбаатар цэргийн хүрээний болон хөдөө орон нутгийн нэгтгэл, ангид автотехникээр осол зөрчилгүй үүрэг гүйцэтгэх 30, 60, 90 хоногийн яныг зохион байгуулан дүгнэлтийг гарган ажиллаж байжээ.

Авто тээврийн хөдөлгөөний шугамын шалгалтыг 1972 онд 205 удаа зохион байгуулж 3200 гаруй автомашинд үзлэг хийж 704 зөрчил илрүүлэн түүнийг засах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр армийн хэмжээнд гарсан осол зөрчлийн тоо 68,7 хувиар буурсан үзүүлэлтийг тухайн цаг үед үзүүлж байв.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1981 оны 246 дугаар тогтоол, НАХЯ, Батлан хамгаалахын сайд нарын хамтарсан 1981 оны 128/412 дугаар тушаалаар Цэргийн автотехникийг шалгах албыг Цэргийн автотехникийн хэргийг шалган байцаах алба болгон өргөтгөн зохион байгуулжээ. Улмаар тус албаны даргаар дэд хурандаа Г.Доржсүрэн Улаанбаатар гарнизоны даргын техник хариуцсан орлогч дарга, цэргийн сахилга сайжруулах комиссын гишүүний үүрэгт ажилд томилогдсон байдаг.

"Цэргийн авто шалгах" гэсэн бичигтэй УАЗ-469 маркийн автомашинууд, мотоцикл, эргүүлийн 2-3 нэгж техниктэй, бие даасан байртай болж өргөжин БХЯ, ЗХЖШ-ын зохион

байгуулсан Зөвлөлтийн армийн нэгтгэл, ангиудтай хамтарсан дайчилгаатай хээрийн сургуулиудад Цэргийн автотехникийн хэргийг шалган байцаах албаны бие бүрэлдэхүүн автотехникийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахад тавигдсан үүргийг нэр төртэй биелүүлж байлаа. Тухайн үед албаны даргаар хошууч Ц.Шархүү, дэд хурандаа Ш.Энхсайхан нар ажиллаж байжээ.

Цэргийн автотехникийн хэргийг шалган байцаах албыг Батлан хамгаалахын сайдын 1991 оны тушаалаар Цэргийн автотехникийг шалгах алба болгон зохион байгуулж Монголын Ардын Армийн 032 дугаар ангийн үйлчлэх салбарын бүрэлдэхүүнд оруулжээ.

Зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголын Ардын Армийн анги, байгууллагуудын техникийн ажилтан, жолооч нарт замын хөдөлгөөний дүрэм, автотехникийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар хичээл зааж, яриа таниулга хийн "Соёмбо" сониноор зам тээврийн осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангахтай холбогдсон асуудлаар сэрэмжлүүлэг, зөвлөмж нийтлүүлэн ажилласан нь ач холбогдолтой арга хэмжээ болсон байна.

Тус албыг Батлан хамгаалахын сайдын 1994 оны тушаалаар **Зэвсэгт хүчний Цэргийн техник шалгах алба** болгон бүтэц, орон тоог батлан мөрдүүлжээ. Улмаар Зэвсэгт хүчинд хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх дөрвөн жилийн хөтөлбөрийг боловсруулан сүүлийн таван жилд гарсан зам тээврийн осолд дүн шинжилгээ хийж, зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлийн нөхцөл шалтгааныг тодорхойлон, "Шат дараалсан албан тушаалтнуудын үүрэг" сэдвээр үзүүлэх сургуулийг Улаанбаатар цэргийн хүрээний болон орон нутгийн

анги, байгууллагад зохион байгуулан ажилласан.

ЗХЖШ-ын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр **Зэвсэгт хүчний Цэргийн техник шалгах албыг** Зэвсэгт хүчний Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах албаны бүтцэд оруулан тасгийн зохион байгуулалтад шилжүүлэн ажиллаж байжээ.

Энэхүү албаны автотехникийн хяналтын тасаг нь Зэвсэгт хүчний хэмжээнд автотехникийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд зохицуулалт хийж тээврийн хэрэгслийн ашиглалт, тавиулангийн албаны үйл ажиллагаанд хяналт, шалгалт зохион байгуулан явуулж иржээ.

Зэвсэгт хүчний Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах албаны автотехникийн хяналтын тасгийг ЗХЖШ-ын даргын 2006 оны 45 дугаар тушаалаар **Зэвсэгт хүчний Хяналт, шалгалт, үнэлгээний газрын автотехникийн хяналтын алба** болон өргөтгөн зохион байгуулжээ.

Эл албанаас анги, байгууллагуудын жолооч, техникийн ажилтнуудад зориулан замын хөдөлгөөний дүрмийн шалгалтын карт, ТШНБ-ны даргын ажлын дэвтэр шинээр хийж хүргүүлэн, "Цэргийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт, зохицуулалт зохион байгуулах журам", "Зэвсэгт хүчний анги, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн авто-хуягт техник хяналт-шалгалт явуулж дүгнэх заавар", "Зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай" Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаал боловсруулж батлуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан.

ЗХЖШ-ын даргын 2016 оны тушаалаар Зэвсэгт хүчний Хяналт, шалгалт, үнэлгээний газрын автотехникийн хяналтын албыг Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба болгон өргөтгөн зохион байгуулжээ.

**АЛБАНЫХАА НЭР ХҮНДИЙГ ӨНДӨРТ
ӨРГӨЖ ЯВНА**



Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагч, ахлах дэслэгч Э.ӨНӨБОЛД:

-Би тус албанд 2019 онд Чингэлтэй дүүргийн замын цагдаагийн хэлтсээс хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагчаар томилогдож ирсэн. Албандаа анх томилогдсон өдрөө олон улсын "Авто ралли" тэмцээний тамирчдыг манай орны нутаг дэвсгэрээр дайран өнгөрөх үед хамгаалалтад үүрэг гүйцэтгэхээр төрсөн нутаг Дундговь аймаг руу томилолт авч байв. Харин буцаж ирээд л Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний хамт Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцох тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулахаар Дорноговь аймгийг зорьсон нь шинээр томилогдсон надад хамгийн анхны том ажлын туршлага болж байлаа.

Цэргийн алба хаагчдын үйл ажиллагаа нь дүрэм, журмаар тогтоогдсон, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг өдөр шөнө, цаг агаарын ямар ч нөхцөлд биелүүлдэг нь энгийн иргэдтэй харьцаж ажиллаж ирсэн надад илүү эрч хүч, урам зориг өгч байсан. Цаашид энэ албандаа идэвх зүтгэлтэй, тогтвор суурьшилтай ажиллаж албаныхаа нэр хүндийг өндөрт өргөж явна гэж боддог. Мөр зэрэгцэн ажиллаж байгаа хамт олондоо болон гавьяаныхаа амралтад гарсан үе үеийн ахмад буурлууддаа түүхт ойн байрын мэндийг хүргэж эрүүл энх, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

АЛБААРАА БАХАРХАЖ ЯВДАГ



Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагч, дэслэгч М.АРИУН-ЭРДЭНЭ:

-Би 2016 онд ЗХЖШ-ын даргын тушаалаар тус албанд зохицуулагчаар томилогдсон. Шинэ байгууллага, шинэ албанд ирэхэд манай хамт олон халуун дотноор хүлээн авсан нь надад үнэхээр сайхан мэдрэмж төрүүлж байлаа.

Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагчаар ажиллах хугацаанд олон зүйлд суралцахын зэрэгцээ, цэргийн техник, цэргийн жолоочийн онцлогийн талаар мэдлэг туршлагатай болж, олон удаа хээрийн дадлага сургуульд тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулан ажиллаж байгаагаараа бахархаж явдаг.

**ЦААШИД ТҮҮЧЭЭЛЭН АЖИЛЛАНА
ГЭДЭГТ ИТГЭЛТЭЙ БАЙНА**

Цагдаа зохицуулагч, ахлах ахлагч М.СУМЪЯА:

-Миний бие тус албанд 2010 оноос цагдаа зохицуулагчаар ажиллаж байна. Энэ хугацаанд жил бүрийн тээврийн хэрэгслийн тооллого, техникийн хяналтын улсын үзлэгээр хөдөө орон нутгийн анги, салбаруудад ажиллах, хээрийн сургууль дадлага, гадаадын зочид төлөөлөгчдийн хамгаалалтад үүрэг гүйцэтгэх хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагчидтай хамтран 11 жил ажиллажээ.

Энэ хугацаанд Монгол Улсынхаа 21 аймгийг 11 удаа тойрч 500.000 гаруй км замыг туулан үүрэг гүйцэтгэсэн байдаг. Миний ажлын онцлог нь албаны эргүүл хамгаалалтын автомашины техникийн бэлэн байдлыг хангаж, ажилд гарахад байнга бэлэн байлгаж, алба хаагчдыг хүрэх газарт саадгүй хүргэн үйлчлэхэд оршдог юм.

**ЦЭРГИЙН САЛБАР НАДАД ОЛОН
ЗҮЙЛИЙН СУРГАСАН**



Цагдаа зохицуулагч, ахлах ахлагч Н.ПҮРЭВЦОГТ:

-Тус албанд томилогдож ирээд удаагүй байхад Улс тунхагласны баяр тохиож байсан. Тэр үед Төрийн Есөн хөлт цагаан тугийн хамгаалалтад гарч, морьтон цэргүүдийнхээ дэргэд нь үүрэг гүйцэтгэж байх үедээ, цэргийн анги, байгууллагуудын байлдааны техникүүдийн цувааны хамгаалалтад ажиллахдаа өөрөөрөө болон албаараа бахархан, омогших сэтгэгдэл төрж байлаа.

Зэвсэгт хүчний хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, зам тээврийн гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан зохицуулагч нартай хамтран үүрэг гүйцэтгэж байгаадаа баяртай байдаг.

— ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС —

1971-1981
1981-1991
1991-1994
1994-2003
2003-2006
2006-2016
2016 оноос

Цэргийн автотехникийг шалгах алба
Цэргийн автотехникийн хэргийг шалган байцаах алба
Цэргийн автотехникийг шалгах алба
Зэвсэгт хүчний Цэргийн техник шалгах алба
Зэвсэгт хүчний Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах албаны Автотехникийн хяналтын тасаг
Зэвсэгт хүчний Хяналт, шалгалт, үнэлгээний газрын Автотехникийн хяналтын алба
Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба



— ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ —

- 1973-1975 онд Хужирбуланд 60 автомашин хадгалах байрыг шинээр бариулах ажлыг зохион байгуулсан.
- 1981-1990 онд автомашины ашиглалт, эзэмшлийг сайжруулах зорилгоор армийн хэмжээнд жолооч, техникийн ажилтнуудыг аттестатчилах ажлыг зохион байгуулан явуулж, зөрчилтэй тээврийн хэрэгслийг түр саатуулах журмын хашааг бариулах, байнгын болон хөдөлгөөнт хяналтын байр байгуулсан.
- 1991-1994 онд Зэвсэгт хүчний хэмжээнд жолооч, техникийн ажилтнуудын жолоочийн ангилал ахиулах, жолоодох эрхийн үнэмлэх, талоньг шинэчлэн олгосон.
- 1944-2003 онд Цагдаагийн ерөнхий газрын даргын 1996 оны 190, 1997 оны 103, БХЯ-ны сайдын 1997 оны 207, ЗХЕШ-ын даргын 1998 оны 154 дүгээр тушаалуудыг хэрэгжүүлэн 1998 оны улсын үзлэг, тооллогоор Зэвсэгт хүчний бүх анги, байгууллагуудын тээврийн бүлгийн автомашинуудын улсын дугаарыг сольж шинэчилсэн.
- 2003-2006 онд ЗХЖШ, Цагдаагийн ерөнхий газартай хамтран ажиллах гэрээг шинээр байгуулан албаны үйл ажиллагаанд хэрэгжүүлж эхэлсэн.
- 2003-2006 онд Автотехникийн хяналтын албаны бие бүрэлдэхүүн цагдаагийн дүрэмт хувцсыг хэрэглэж, алба хаагчийн хувийн дугаар, "А" серийн үнэмлэхтэй, Замын цагдаагийн газрын байцаагч, зохицуулагчийн нэгэн адил эрх, үүрэгтэй болсон.
- Албаны эргүүл, хамгаалалтын автомашинуудыг тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага, стандартад нийцсэн техник хэрэгслээр тоноглож, албаны мэдээлэл, шуурхай ажиллагааг ханган суурин станцаар тоноглож Замын цагдаагийн газрын радио холбооны сувагт холбоулсан.
- Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчдыг мотоциклын "А" ангиллын сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан.
- Албаны жижүүрийн байрыг тохижуулж хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслүүдийг хянах байршил тогтоогч, хяналтын дэлгэц, Тээврийн цагдаагийн албатай холбогдох суурин станц, Цагдаагийн ерөнхий газрын зөрчлийн мэдээллийн санд холбогдох дотоод сүлжээнд нэгдсэн.
- Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын тээврийн бүлгийн автомашинуудын улсын дугаарыг Монгол Улсын стандартад нийцүүлэн хар дэвсгэртэй болгон өөрчлөх ажлыг зохион байгуулсан.
- Албаны бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулж хөдөө орон нутаг дахь цэргийн хүрээ, хотхон хариуцсан тээврийн хяналтын байцаагч нарыг томилуулсан.
- Аймаг, нийслэл, дүүргүүдийн прокурорын газраас зөрчлийн хэрэг хянан шийдвэрлүүлэх ажиллагаа явуулж эхэлсэн.

